

САНАЛ ӨГӨХ 7 АЛХАМ

Сонгуульд саналаа өгснөөр төрийн эрх барих эрхээ дөрвөн жилд нэг удаа эдэлдэг ч үүнийг зөвхөн нэг өдрийн хэрэг мэтээр хандаж болохгүй нь. Харин энэ нь бүхэл бүтэн 4 жилийн турш, нэг сонгуулиас дараагийн сонгууль хүртэл үргэлжилдэг хариуцлагатай оролцоо юм.

Хариуцлагатай сонгогчийн зайлшгүй анхаарах “Санал өгөх 7 алхам”

1-р алхам. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх, бүртгэгдсэн бол алдаа мадаггүй бүртгэгдсэн эсэх, бүртгэгдээгүй бол хуульд заасан журмын дагуу Улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх;

2-р алхам. Сонгуульд оролцож буй нам, эвслийн мөрийн хөтөлбөр, алсын хараа, үзэл баримтлал, нэр дэвшигчдийн мэдлэг боловсрол, чадвар, ажлын туршлагын талаар хангалттай мэдээлэл цуглуулах;

3-р алхам. Цуглуулсан мэдээллээ судалж, нам, эвсэл, нэр дэвшигчдийг харьцуулан үнэлж, цэгнэх;

4-р алхам. Та өөрийн болон улс орны ирээдүйг найдан даатгаж болох, итгэл даах улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг шилж сонгох;

5-р алхам. Сонгуулийн санал авах өдөр сонгуулийн санал авах байр руу очоод саналаа өгөөрэй. Та өөрийн төлөөллөө сонголоо.

6-р алхам. Сонгуулийн дараа ч сонгосон төрийн түшээдийнхээ үйл ажиллагааг нь сайтар ажиглаж, үнэлж байх;

7-р алхам. Бүрэн эрхийн хугацаа өнгөрсний дараа тэдгээр улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн төлөө дахин санал өгөх эсэхээ шийдээрэй.